

**“АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
П.МӨНХ-ЭРДЭНИЙН 2022 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021.04.05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2022 оны 03 дугаар улирлын ажлын тайланг хүргүүлж байна.

Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 1 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 3 удаа хуульд заасны дагуу танхим, цахим хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнээс:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын талаар:

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 1 удаа хуралдсан. ТУЗ-ийн дарга миний бие гадаад улсад албан томилолттой байх үеэр хурлын хугацаа товлогдсон учир КТХ-ийн “78.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон гишүүн гүйцэтгэнэ” гэсэн заалтын дагуу ТУЗ-ийн ердийн гишүүн С.Хосбаярыг 2022 оны 7 дугаар сарын 04 өдрийн Т/22/37 дугаартай ТУЗ тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг даргалуулахаар томилсон. Уг хурлаар “Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын 3 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Н/95, Н/97 тоот албан бичгээр ирүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зөвшөөрөл зэргийг үндэслэн банкны дүрмийн санг 100 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх шийдвэрийг гарган батлаж бүртгэлийн байгууллагад дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэхээр хүргүүлсэн. Энэхүү батлагдсан дүрэмд зааснаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нийт 4726 ширхэг хувьцаанаас бүрдсэн 100,033,190,443 төгрөг болж нэмэгдсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал даргалсан, оролцсон байдлын тайлан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 7 дугаар сард 1, 9 дүгээр сард 2, улиралдаа нийт 3 удаа хуралдсан.

1. 2022 оны 7 дугаар сарын 04-ний өдөр хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлын ирц бүрэн, ТУЗ гишүүд бүгд оролцсон. Хурлаар 3 асуудлыг хэлэлцсэн.
 - хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын товыг зарлах (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022.06.30-ны өдрийн Н/95, Н/97 дугаартай “Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, бүтцийг өөрчлөх тухай” албан бичиг ирсэн учир банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт оруулсан дүрмийг батлах асуудлыг хэлэлцэх)
 - Банкны 40 мянгат тооцооны төвийн байршлыг өөрчлөх, сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах,
 - Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК-ийн 2.0 тэрбум төгрөгийн бизнесийн шугамын зээлийн хүсэлтийн талаар хэлэлцэх

Хэлэлцүүлсэн асуудлын дагуу ТУЗ-ийн хуралд оролцсон ТУЗ гишүүдийн олонхитой 1 байр сууринаас ижил саналыг гаргаж, хурлаас нийт 4 тогтоол гарган батласан.

Хэлэлцүүлсэн 1-р асуудлын тухайд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр хуралдуулах, хурлын даргаар С.Хосбаярыг томилох, хурлаар дүрмийн өөрчлөлтийг батлахаар Т/22/37 дугаартай тогтоолыг хурлаас батлан гаргасан.

Хэлэлцүүлсэн 2-р асуудлын тухайд: Банкны 40 мянгат тооцооны салбарын байрны түрээсийн хугацаа дуусч 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Т/22/25 дугаартай ТУЗ тогтоолоор түрээсийн хугацааг 3 жилээр сунгаж, сард 22,7 сая төгрөгөөр түрээслэх зөвшөөрөл олгож гэрээ хийх эрхийг олгон шийдвэрлэж байсан боловч түрээсийн байрны эзэмшигч дахин үнээ нэмэгдүүлж, гэрээний хугацааны хувьд зөвшилцөж чадаагүй тул, тус салбарыг шилжүүлэн байршлыг өөрчлөж УИД-ийн 1 давхарт түрээслэхээр гэрээ хийх зөвшөөрлийг олгон уг асуудлыг сонирхлыг зөрчилгүй хараат бус гишүүдийн 100%-ийн саналаар Т/22/38 дугаартай ТУЗ тогтоолоор батласан.

Хэлэлцүүлсэн 3-р асуудлын тухайд: Нэткапитал финанс корпораци ББСБ-аас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэн 2 тэрбум төгрөгийн шугамын зээлийн эрх нээлгэх гэрээ хэлцэл хийх эрхийг гүйцэтгэх захиралд олгосон Т/22/40 дугаартай ТУЗ тогтоолыг гарган батласан. Энэ асуудалд хараат бус гишүүн Д.Түвшинтамир татгалзаж, бусад гишүүд дэмжсэн учир КТХ-ийн “80.6.Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно” гэсэн заалтаар уг асуудлыг батлан шийдвэрлэсэн. Хараат бус гишүүн миний хувьд хэлэлцсэн асуудлыг дэмжсэн саналтайгаар оролцсон.

2. 2022-09-05-ны өдөр 11 цагаас танхим, цахим хосолсон байдлаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хуралд 4 гишүүн танхимаар, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Түвшинтамир гадаад улсаас цахимаар холбогдож, гишүүд бүгд ирц бүрэн хуралдаа оролцсон. Хурлаар 3 асуудлыг хэлэлцсэн.

- Номин тав трейд ХХК-тай хамтарсан бизнес карт гаргахаар хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх зөвшөөрөл олгох
- Банкны эрх бүхий албан тушаалтан, түүний холбоотой этгээдэд зээл олгох гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоох
- Банкны хэрэгцээнд шаардлагатай байгаа компьютер тоног төхөөрөмжийн худалдан авалт хийх эрх олгох, үнийг батлах

Хэлэлцүүлсэн 1-р асуудлын тухайд: Номин тав трейд ХХК-ийн ханган нийлүүлэгчиддээ зориулан гаргадаг “Номин бонус карт”-ыг Ариг банкны кредит/дебит карттай нэгтгэн хамтарсан бизнес карт гаргах зорилгоор Номин тав трейд ХХК-тай Хамтран ажиллах гэрээг байгуулахыг зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурах эрхийг гүйцэтгэх захиралд олгон Т/22/41 тогтоолыг батласан. Хуралд оролцсон ТУЗ-ийн ердийн гишүүд нь энэ асуудалд сонирхлын зөрчилтэй тул КТХ-ийн 92.1-д зааснаар уг асуудалд сонирхлын зөрчилгүй, хараат бус 2 гишүүдийн 100%-ийн саналаар шийдвэрлэсэн.

Хэлэлцүүлсэн 2-р асуудлын тухайд: Банкны эрх бүхий албан тушаалтанд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 3%-иас ихгүй, тэдгээртэй холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 17%-иас ихгүй байхаар тус тус тооцож зээлийн хүсэлт шийдвэрлэж, зээл олгох, холбогдох гэрээ,

хэлцлийг байгуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгож хуралд оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар зөвшөөрч, Т/22/42 тогтоолыг батласан.

Хэлэлцүүлсэн 3-р асуудлын тухайд: Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах компьютер, түүний дагалдах хэрэгслийг 155 сая төгрөгийн үнээр худалдан авах, худалдан авалтын нөхцлийг тохиролцон И Номин ХХК-тай Худалдах, худалдан авах гэрээг байгуулахыг зөвшөөрч Т/22/43 тогтоолыг батласан. Хуралд оролцсон ТУЗ-ийн ердийн гишүүд нь энэ асуудалд сонирхлын зөрчилтэй тул КТХ-ийн 92.1-д зааснаар уг асуудалд сонирхлын зөрчилгүй, хараат бус 2 гишүүдийн 100%-ийн саналаар шийдвэрлэсэн.

3. 2022-09-14-ны өдөр 11 цагаас танхимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хуралд ТУЗ-ийн гишүүд бүгд хүрэлцэн ирж, ирц бүрэн хуралдсан. Хурлаар 2 асуудлыг хэлэлцсэн.
 1. Ариг банкны төв оффисын үл хөдлөх хөрөнгийг худалдан авах саналыг танилцуулах,
 2. Аудитын хорооноос хэлэлцүүлэх асуудлууд

Хэлэлцүүлсэн 1-р асуудлын тухайд банкнаас оруулж ирсэн танилцуулга материалтай танилцаад дахин нарийвчлан судлуулахаар буцаасан. Шийдвэр гаргаагүй.

Хэлэлцүүлсэн 2-р асуудлын тухайд: ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дэргэд ажилладаг Дотоод аудитын газрын “Дотоод аудитын дүрэм”, “Дотоод аудитын үйл ажиллагааны заавар”, “Дотоод аудитын ёс зүйн дүрэм” зэрэг баримт бичгийг хэлэлцүүлэн хуралд оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар Т/22/45 тоот тогтоолын хавсралтаар батлан шийдвэрлэсэн. Гишүүдээс санал зөрсөн асуудал гараагүй, хараат бус гишүүн миний хувьд хэлэлцсэн асуудлыг дэмжсэн саналтайгаар оролцсон.

Энэ хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хуралд 2 удаа оролцож дээрх баримт бичгийн боловсруулалтанд саналаа өгч ТУЗ-ийн хуралд танилцуулан батлуулж ажилласан болно. ТУЗ-ийн хараат бус гишүүн миний хувьд дээрх хурлуудад хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй болно. Мөн эдгээр хурлуудын хэлэлцэх асуудалд ашиг сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах асуудал ороогүй болохыг дашрамд дурдаж байна.

Тайлан бичсэн:: ТУЗ-ийн дарга,

хараат бус гишүүн

П.Мөнх-Эрдэнэ

